



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/738

Булган сум

**Хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ  
зохион байгуулахыг хориглох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, Хүүхдийн эрхийн конвенцын 6 дугаар зүйлийн 6.2, 24 дүгээр зүйлийн 24.3, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Засгийн газрын 2019 оны "Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" А/57 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн хэмжээнд 2023 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглосугай.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга болон аймаг, сумын Морин спорт уяачдын холбооны тэргүүн нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Т.Баярбат), Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Г.Ганбаяр), нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ